



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 06 өдөр

Дугаар A/358

Ховд

Газар ашиглах эрхийн гэрчилгээний  
хугацаа сунгах тухай

Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэг, 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Баатархайрхан багт байрлах Шинэ суурьшлын бүсэд амины орон сууцны хороолол барих зориулалттай 8414006620 нэгж талбарын дугаар бүхий 29.2 га газраас 15 га газрыг “Мон-Лун хөгжил” ХХК /6005705/-д, үлдсэн 14.2 газрыг хүчингүй болгон газар ашиглах эрхийн гэрчилгээний хугацааг 5 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Газар ашиглах эрх нь сунгагдсан аж ахуй, нэгжтэй газар ашиглах гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/358 Ch

02 01736